



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 10 сарын 28 өдөр

Дугаар A/358

Улаанбаатар хот

**Монгол-Оросын хамтарсан
сургуулийн эргэлтийн бус
хөрөнгийг данснаас хасах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 38,412,918 (гучин найман сая дөрвөн зуун арван хоёр мянга есөн зуун арван найм) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан ном, сурах бичгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Монгол-Оросын хамтарсан сургууль (Ж.Соронзон)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй 27 нэр төрлийн 6503 ширхэг нийт 38,412,918 (гучин найман сая дөрвөн зуун арван хоёр мянга есөн зуун арван найм) төгрөгийн үнэ бүхий ном, сурах бичгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгаж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Монгол-Оросын хамтарсан сургууль (Ж.Соронзон)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050000981



Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2021 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/338 тоот тушаалын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: **Монгол Оросын хамтарсан сургууль**

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжлэн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын үнийн санал	Мэргэжилтний санал	ЭБХХК-ийн хурлын шийдвэр
Номын фонд													
1	Ном, сурах бичиг	10-21 жил	ш	27 нэрийн 6503 ширхэг		38,412,918.0	38,412,918.0	-	Агуулга стандарт өөрчлөгдсөн, эрүүл ахуйн шаардлага хангахгүй болсон.	актлах	устгах	устгах	устгах
Номын фондын дүн													
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн													
Үүнээс: Худалдах хөрөнгө													
Устгах хөрөнгө													
Худалдсанаас олох орлого													
НӨАУГ-т төвлөрүүлэх /30%/													